

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ

(2021 оны нэгдүгээр улирлын байдлаар)

2021 оны 03 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 10-ны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д нийцүүлэн өргөдөл гомдол шийдвэрлэлийг 2021 оны нэгдүгээр улиралд дараах байдлаар зохион байгуулсан ажиллалаа.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хугацаан нийт 24 өргөдөл ирсэнийг www.erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд программын тусламжтайгаар илгээн, 23 өргөдлийг шийдвэрлэж хариуг өгсөн байдлаар шийдвэрлэгдэх шатанд байгаа 1 өргөдөл байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ

Байгууллагад ирсэн өргөдөлыг хандалтын төрлөөр нь ангилвал:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл, хүсэлт – 3;
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл, хүсэлт – 5;
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл, хүсэлт – 10;
- Жирэмсний амралт хүссэн өргөдөл, хүсэлт – 5;
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл, хүсэлт – 1;

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:



График 1: Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал

Хүснэгт 1

Д/д	Хугацаа	2020.01	2020.02	2020.03	2020.04	2021.01
-----	---------	---------	---------	---------	---------	---------

		улирал	улирал	улирал	улирал	улирал
Ерөнхий үзүүлэлт						
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	7 хоног 14 цаг 19 минут	5 хоног 15 цаг 21 минут	3 хоног 11 цаг 53 минут	5 хоног 9 цаг 23 минут	2 хоног 18 цаг 30 минут
2	Хандалтын тоо	53	43	46	60	24
3	Зөрчлийн үзүүлэлт	1	2	1	0	0
Өргөдөл, гомдлын хандалтын төрөл						
4	Хөдөлмөрийн хөлсний тухай	10	11	2	13	3
5	Захиргааны чөлөө хүсэх тухай	14	6	16	15	5
6	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл, хүсэлт	17	11	17	13	10
7	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй өргөдөл	8	8	4	7	5
8	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл,	4	6	6	12	1




График 2. Өргөдлийн тоо, шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал

Графикаас харахад газрын хэмжээнд 2021 оны 1 дүгээр улиралд ирсэн өргөдлийн тоо өмнөх улирлаас 60%-иар, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоногоор тус тус буурсан байна.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор

явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй 10 өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад өдөрт нь шилжүүлж ажиллалаа.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,

ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Н.БУЛГАНЧИМЭГ